



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 3764

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 172 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 172 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1 дэх хэсэг, Газрын даргын 2021 оны Б/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар, үл хөдлөх хөрөнгө хаягийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Байнгын ажиллагаатай суурин станц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн Орон зайн өгөгдлийн боловсруулалт, загварчлал хариуцсан инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Орон зайн өгөгдлийн сангийн үйлчилгээ, хөгжүүлэлт хариуцсан инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНХҮҮ

1512100208